



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 49, 65 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг 1 дүгээр, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний загварыг 2 дугаар, төрийн өмчит компанийн захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний загварыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ журмыг мөрдөж ажиллахыг төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчийн (100 хувь) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тус тус зөвлөсүгэй.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ) -т даалгасугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002214

\Huraldaanii material\2022 on\2022.05.03 12-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн  
11 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАХИРАЛТАЙ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал, захирал, төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ (цаашид “гэрээ” гэх) байгуулах, дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, дүгнэх, урамшуулалт олгох болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн /100 хувь/ компани дагаж мөрднө

1.3. Энэхүү журамд цаашид төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийг “төрийн өмчит хуулийн этгээд”, төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал, захирал, төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирлыг “захирал” гэнэ.

1.4. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг удирдлага болгон төрийн хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах үүрэгтэй.

### Хоёр. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах

2.1. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний загварын дагуу захиралтай нэг хүртэл жилийн хугацаагаар байгуулж болно.

2.2. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, түүнийг төлөөлж Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга гэрээ байгуулж, газрын дарга батална.

2.3. Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан удирдамж, шийдвэрийн дагуу гэрээ байгуулна.

2.4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдол бүхий стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1, 65.2-т заасан нөхцөлөөс гадна энэ журамд заасан нөхцөлийг нэмэгдүүлэн, эсхүл харилцан тохиролцсон өөр нөхцөл тусгаж нэмэлт гэрээ байгуулж болно.

2.5. Хуулийн этгээдийн захирлын гэрээнд тухайн оны батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг болно.

2.6. Гэрээ байгуулсан этгээд нь гэрээнд дугаар олгох бөгөөд гэрээг зохих журам, зааврын дагуу тамга, тэмдгээр баталгаажуулна.

### Гурав. Гэрээг дүгнэх

3.1. Хуулийн этгээдийн захиралтай байгуулсан гэрээг жилийн эцсийн тайлан хэлэлцэх болон тус гэрээний хугацаа дуусгавар болох үед Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, дүгнэлт, салбарын яам болон төрийн захиргааны байгууллагын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, дүгнэлтийг авсны үндсэн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дүгнэнэ.

3.2. Хуулийн этгээдийн захирал нь дараах материалыг бүрдүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дараа оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ:

- 3.2.1. Гэрээний биелэлт;
- 3.2.2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл;
- 3.2.3. Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
- 3.2.4. Аудитын тайлан, зөвлөмж;
- 3.2.5. Аудитын компанийн сүүлийн 2 жилд өгсөн зөвлөмжийн биелэлт;
- 3.2.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн санал дүгнэлт, шийдвэр;
- 3.2.7. Захирлын ажлын тайлан.
- 3.2.8. Харьяалах салбарын яам, төрийн захиргааны байгууллагын үнэлгээ болон шийдвэрийн хэрэгжилтийн тайлан.
- 3.2.9. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өгсөн албан даалгавар, тогтоол шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн тайлан.

3.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах материалыг бүрдүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дараа оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ:

- 3.3.1. Төлөөлөн удирдах зөвлөл болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлын тайлан.
- 3.3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр болон хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл.
- 3.3.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийн тайлан.
- 3.3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ирц, гишүүдийн идэвх оролцоо болон хуралд оролцсон байдлын талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын санал дүгнэлт.
- 3.3.5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өгсөн удирдамж, чиглэлийн хэрэгжилтийн тайлан. /Тайлант онд өгсөн удирдамж, чиглэлийн тоо, хэлэлцсэн асуудлын тоо, гаргасан шийдвэрийн тоо тодорхой байх/

3.4. Энэхүү журмын 3.2, 3.3-т заасан материалыг хугацаанд нь ирүүлэх, хугацаандаа ирүүлэх үүрэгтэй бөгөөд, хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд шалгуур үзүүлэлтийн нийт онооноос 5 оноо хасаж тооцно.

3.5. Энэхүү журмын 3.2, 3.3-т заасан материалыг судалж, санал дүгнэлт боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулна.

3.6. Ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалт хэлтэс болон Захиргаа удирдлага, Хууль эрх зүй, Хяналт шалгалт, Бүртгэл, ашиглалтын асуудал хариуцсан удирдах албан тушаалтныг оруулна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны холбогдох байгууллага, мэргэжлийн болон компанийн засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

3.7. Ажлын хэсэг гэрээг эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны сүүлийн 2 жилийн үзүүлэлт болон энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан үзүүлэлтээр тус тус дүгнэнэ.

3.8. Гэрээний биелэлтийг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно:

д/д	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
1	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл	55
2	Тайлангийн үр дүн, хууль тогтоомжийн биелэлт	20
3	Харьяалах салбарын яам, төрийн захиргааны байгууллагын үнэлгээ (шийдвэрийн хэрэгжилт)	25
	Нийт оноо	100

3.9. Гэрээний биелэлтийг энэ журмын хавсралтад заасан үзүүлэлтээр дүгнэнэ.

3.10. Энэхүү журмын 3.8-д заасан шалгуур үзүүлэлтийн нийт дүнгээр 90-100 оноо авсан бол захирлын гэрээний биелэлтийг "Сайн", 75-89 оноо авсан бол "Хангалттай", 75-аас доош оноо авсан бол "Хангалтгүй" гэж тус тус дүгнэнэ.

3.11. Харьяалах салбарын яам, төрийн захиргааны байгууллага нь эрхлэх асуудлын хүрээний хуулийн этгээдийн ажлын тайлангийн үнэлгээг холбогдох баримт материалын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт дараа оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлэх үүрэг хүлээнэ.

3.12. Захирлын ажлыг дүгнэхэд хуулийн этгээдийн ажилтнууд болон хэрэглэгч үйчлүүлэгчдээс санал асуулга авсан байна. Санал асуулгыг шаардлагатай тохиолдолд хэдэн ч удаа авч болно.

### Дөрөв. Цалин, урамшуулал

4.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн захирлын албан тушаалын сарын үндсэн цалинг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан аргачлалын дагуу тогтооно.

4.2. Гэрээний биелэлт нь "Сайн" гэж дүгнэгдсэн, шинэ санал, санаачилга, ажил зохион байгуулж үр дүн гаргасан, цэвэр ашгийн төлөвлөгөөг биелүүлсэн, жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр

тооцсон төрийн өмчийн ногдол ашгийг бүрэн төвлөрүүлсэн, улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй хуулийн этгээдийн захиралд урамшуулалт олгоно.

4.3. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдийн захиралд урамшуулалт олгох асуудлыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.4. Урамшууллыг валютын ханшийн өөрчлөлтөөс олсон олзийг хассан цэвэр ашгаас тооцох бөгөөд урамшууллын хувийг дараах хүснэгтийн дагуу тогтооно:

Д/д	Цэвэр ашгийн дүн (сая)	Урамшууллын нийт цэвэр ашигт эзлэх хувь	Урамшууллын хэмжээ (сая)
1.	50,0 хүртэл	10	5,0
2.	50,0-250,0 хүртэл	4	5,0 дээр нийт цэвэр ашгийн 2 хувиар тооцсон дунг нэмэх
3.	250,0-500,0 хүртэл	4	10,0 дээр нийт цэвэр ашгийн 1 хувиар тооцсон дунг нэмэх
4.	500,0-1000,0 хүртэл	3	15,0 дээр нийт цэвэр ашгийн 1 хувиар тооцсон дунг нэмэх
5.	1000,0-50000,0 хүртэл	0,08	25,0 дээр нийт цэвэр ашгийн 0,02 хувиар тооцсон дунг нэмэх
6.	50000,0-250000,0 хүртэл	0,022	35,0 дээр нийт цэвэр ашгийн 0,006 хувиар тооцсон дунг нэмэх
7.	250000,0-500000,0	0,016	50,0 дээр нийт цэвэр ашгийн 0,005 хувиар тооцсон дунг нэмэх
8.	500000,0-аас дээш	0,012	75,0 дээр нийт цэвэр ашгийн 0,004 хувиар тооцсон дунг нэмэх

4.5. Захиралд тухайн жилд хуанлийн 91 болон түүнээс дээш хоног ажилласан бол ажилласан хугацаанд нь ногдох хэмжээгээр урамшуулалт олгож болно.

4.6. Захиралд дараах нехцэлд урамшуулалт олгохгүй:

4.6.1. Төрийн өмчийн ногдол ашгийг бүрэн төвлөрүүллээгүй;

4.6.2. Өмч хөрөнгө үрэгдүүлсэн, шамшигдуулсан нь нотлогдсон;

4.6.3. Осол аваарын улмаас хүний амь нас эрсэдсэн, хүнд гэмтэл учирсан, их хэмжээний хохирол гарсан;

4.6.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон;

4.6.5. Тухай жилийн санхүүгийн аудитын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан;

4.6.6. Тухайн жилд хуанлийн 90 болон түүнээс доош хоног ажилласан.

4.7. Үйлдвэрлэлийн технологийн горим, тогтвортой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай төлөвлөгөөт ажил, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хэмнэж олсон ашгийн нөлөөллийг цэвэр ашгаас хасаж тооцно.

4.8. Захиралд олгох урамшууллыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн хуулийн этгээдийн санхүүгийн зохих эх үүсвэрээс гаргана.

### Тав. Хариуцлага

5.1. Гэрээ нь “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн захиралд холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан хариуцлага тооцох саналыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.2. Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцлийг буруу гаргасан нь тогтоогдвол захиралд олгосон урамшууллыг буцаан төлүүлнэ.

-----000-----

“Төрийн өмчт хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 1 дүгээр хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН  
ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ  
ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

Дүгнэх үзүүлэлт		Үнэлгээнд тавих оноо
1	Нийт орлого	5.0
2	Нийт зардал	5.0
3	Цэвэр ашиг /алдагдал/	5.0
4	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	5.0
5	Нийт авлага	5.0
6	Нийт өглөг (Өр төлбөр/Эздийн өмчийн зохистой харьцааг харгалзах. 1-с дээш бол эрсдэлд орж эхэлж байгаа, 2-с дээш бол өндөр эрсдэлтэй, Эздийн өмчийн дүн (-) үзүүлэлттэй бол маш өндөр эрсдэлтэй)	5.0
7	Хөрөнгө оруулалт	5.0
8	Хөрөнгийн өгөөжийг сайжруулсан байдал (Нийт хөрөнгө/Татварын өмнө ашгийн дүн. Сүүлийн 5 жилийн дундаж өссөн дүнгээр харьцуулж үзэх ба харьцуулалтын дүнг харгалзаж зохих оноог өгнө)	10.0
9	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх	10.0
Нэг. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл		55
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт	5.0
2.2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон ТҮЗ-ийн шийдвэрийн биелэлт	5.0
2.3	Худалдан авах ажиллагааны тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт	4.0
2.4	Хэрэглэгчийн санал асуулгын дүн	3.0
2.5	Ажиллагсадын санал асуулгын дүн	3.0
<b>Хоёр. Тайлангийн үр дун, хууль тогтоомжийн биелэлт</b>		<b>20.0</b>
<b>Гурав. Харьяалах салбарын яам, төрийн захиргааны холбогдох байгууллагын үнэлгээ /шийдвэрийн хэрэгжилт/</b>		<b>25.0</b>
	<b>НИЙТ ОНОО</b>	<b>100.0</b>

“Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралт

## ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС ТОГТООХ АРГАЧЛАЛ

1. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит гүйцэтгэх захирлын албан тушаалын сарын хөдөлмөрийн хөлсийг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоолыг үндэслэн хуулийн этгээдийн нийт хөрөнгийн хэмжээ, ажиллагсадын тоо, тайлант жилийн цэвэр ашгийн хэмжээгээр эрэмбэлж дор дурдсан кофициентүүдэд харгалзуулан тогтооно.

а. Нийт хөрөнгийн хэмжээгээр:  $K_x = 0.7, 0.9, 1.2, 1.6, 2.0$

Хөрөнгийн хэмжээгээр:

1.0 тэрбум төгрөг хүртэл	$K_x = 0.7$
1.0 – 10.0 тэрбум төгрөг хүртэл	$K_x = 0.9$
10.0 – 100.0 тэрбум төгрөг хүртэл	$K_x = 1.2$
100.0 – 1.0 их наяд төгрөг хүртэл	$K_x = 1.6$
1.0 их наяд төгрөгнөөс дээш	$K_x = 2.0$

б. Нийт ажиллагсадын тоогоор:  $A_t = 0.7, 0.9, 1.2, 1.6, 2.0$

Ажиллагсадын тоо:

100 хүртэл ажиллагсадтай	$A_t = 0.7$
100 – 500 хүртэл ажиллагсадтай	$A_t = 0.9$
500 – 1000 хүртэл ажиллагсадтай	$A_t = 1.2$
1000 – 1500 хүртэл ажиллагсадтай	$A_t = 1.6$
1500 – ээс дээш ажиллагсадтай	$A_t = 2.0$

в. Цэвэр ашгийн хэмжээгээр:  $K_a = 0.7, 0.9, 1.2, 1.6, 2.0$

Цэвэр ашгийн хэмжээгээр:

100.0 сая төгрөг хүртэл	$K_a = 0.7$
100.0 – 500.0 сая төгрөг хүртэл	$K_a = 0.9$
500.0 – 1.0 тэрбум төгрөг хүртэл	$K_a = 1.2$
1.0 – 100.0 тэрбум төгрөг хүртэл	$K_a = 1.6$
100.0 тэрбум төгрөгнөөс дээш	$K_a = 2.0$

\*Тухайн хуулийн этгээдийн нийт хөрөнгө, ажиллагсадын тоо, цэвэр ашгийн хэмжээг жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан тоогоор авна.

2. Гүйцэтгэх захирлын үндсэн цалинг хуулийн этгээдийн санхүүгийн чадавхи, үйл ажиллагааны онцлог, цар хүрээ зэргийг үндэслэн гэрээ байгуулахаас өмнө тогтооно.

3. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалын сарын хөдөлмөрийн хөлсийг дараах томъёогоор бодож гаргана.

$$\frac{\text{Цалин} = 9 \times \text{Ко}}{3} \quad (Kx + At + Ka)$$

Ко – Засгийн газар буюу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

4. Гүйцэтгэх захирлын гэрээг дүгнэх үед тайлант жилийн ажлын үр дүнг харгалзан үндсэн цалинг жил бүр шинэчлэн тогтооно.

5. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн Гүйцэтгэх захирлын гэрээний биелэлт, гүйцэтгэх удирдлагын нэвтрүүлсэн шинэлэг арга барил, шинэ дэвшилтээ техник, технологи, зах зээлд гаргасан шинэ нэрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, санхүүгийн менежментийн талаар олсон үр дүн зэргийн харгалзан, мөн стратегийн ач холбогдол бүхий томоохон хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын сарын хөдөлмөрийн хөлсийг тогтоохдоо цалин тогтоох гурван үзүүлэлтээр авсан дундаж коэффициентийг 1,5-3 дахин нэмэгдүүлэн тогтоож болно.

6. Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит гүйцэтгэх захирлын ажлыг сар, улирал бүр санхүү, үйлдвэрлэлийн дотоод үйл ажиллагаа, хэрэглэгчдэд үзүүлсэн үйлчилгээ, хүний нөөцийн асуудал, гаргасан шийдвэрийн биелэлт зэрэг тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнэж, гүйцэтгэл биелэлтийн хувиар тооцон тухайн сар, улиралд олгох үндсэн цалинг өсгөж, бууруулж олгож болно.

7. Гүйцэтгэх захирлын сар, улирлын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тогтоох, биелэлтийг гаргаж дүгнэх, цалинг өсгөж, бууруулж олгох асуудлыг тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

8. Төлөөлөн удирдах зөвлөлгүй хуулийн этгээдийн ерөнхий захирал, захирал, гүйцэтгэх захирлын сар, улирлын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тогтоох, биелэлтийг тооцох, цалинг өсгөж, бууруулах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шийдвэрлэнэ.

---оОо---

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны ..... дугаар сарын .....-ны өдрийн  
..... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

БАТЛАВ: ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

“.....” ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ  
ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

202... оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар: .....

Улаанбаатар  
хот

Энэхүү онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг (цаашид “Гэрээ” гэх) нэг талаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, түүнийг төлөөлж Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга ..... (цаашид “ажил олгогч” гэх), нөгөө талаас “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал ..... (цаашид “захирал”, хамтад нь “талууд” гэх) нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1, 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 оны ... дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ, борлуулалт, эдийн засгийн үр ашиг, хөрөнгийн өгөөжийг өмнөх онд төлөвлөсөн хэмжээнээс дээшлүүлэн, гэрээгээр хүлээсэн үүргээ ханганд биелүүлэхтэй холбогдсон хөдөлмөрийн харилцааг зохицуулах, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү гэрээ нь 20..... оны .... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 20..... оны .... дугаар сарын .....-ны өдрийг дуустал хугацаанд хүчинтэй байна.

1.3. “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын 20.... оны .... дугаар улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан ..... (.....) төгрөгийн үндсэн, ..... (.....) төгрөгийн эргэлтийн, нийт..... (.....) төгрөгийн хөрөнгийг гэрээ байгуулсан өдөр хүлээлгэн өгөв.

1.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын 20.... оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд захирлын хийх ажлын хүрэх үр дүн болно.

1.5. “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын тухайн жилийн үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь гэрээний хэрэгжилтийг дүгнэх үндсэн үзүүлэлт болно.

Гэрээг жил бүр “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу дүгнэнэ.

1.6. Гэрээг сунгахаар шийдвэрлэсэн нөхцөлд аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан үндсэн болон эргэлтийн хөрөнгийг сүүлийн байдлаар хүлээлгэн өгнө.

### **Хоёр. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх, үүрэг**

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дараах эрхийг хэрэгжүүлнэ:

2.1.1. “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх;

2.1.2. Тус үйлдвэрийн газрын 2021 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр төрийн өмчийн ногдол ашгийг тооцож тогтоох;

2.1.3. Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тоо, цалингийн сангийн хэмжээг тогтоох;

2.1.4. Тус үйлдвэрийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, захирлын үйл ажиллагааны тайлан, гэрээний үүргийн биелэлтийг хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.5. Захиралд олгох үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, нөхөн олговор, буцалтгүй тусламж, тэтгэмжийн хэмжээг тогтоох;

2.1.6. Ажлын явц, гүйцэтгэлтэй улирал бүр танилцаж санал, зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

2.1.7. Шаардлагатай тохиолдолд тус үйлдвэрийн газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох яам, газартай хамтран хяналт шалгалт хийх;

2.1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн, бодитой биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомж, энэ гэрээний дагуу хариуцлага ногдуулах;

2.1.9. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлог, ажлын шаардлагыг харгалzan удирдлагын зөвлөлийг томилон ажиллуулах;

2.1.10. Захирал 30-аас дээш хоногийн хугацаагаар эзгүй байх (Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй) тохиолдолд захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилох;

2.1.11.Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх.

2.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дараах үүргийг хүлээнэ:

2.2.1. Захиралд холбогдох журмын дагуу тогтоосон үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, үйл ажиллагааны үр дүнд нь тохирсон шагнал, урамшуулалыг олгох;

2.2.2. Захирлыг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдах ажилд мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.3. Захирлын гэрээний үүргээ биелүүлэхтэй холбогдуулж тавьсан албан саналд тухай бүр хариу өгөх, холбогдох мэдээллээр хангах;

2.2.4. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

### **Гурав. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын эрх, үүрэг**

- 3.1. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал дараах эрхийг хэрэгжүүлнэ:
- 3.1.1. Тус үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр гадаад, дотоодод төлөөлөх, итгэмжлэл олгох;
- 3.1.2. Өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй гэрээ, хэлцэл хийх, байгуулах;
- 3.1.3. Хүний нөөцийн бодлого боловсруулж батлах;
- 3.1.4. Үйлдвэрийн газрын ажилчин, ажилтан, албан тушаалтныг сургах, давтан сургах, холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжүүлэх;
- 3.1.5. Үйлдвэрийн газрын эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмших, ашиглах хэлбэрээр захиран зарцуулах;
- 3.1.6. Үйлдвэрийн газрын цэвэр ашгийн чөлөөт үлдэгдлээс захирлын зөвлөл (удирдлагын баг)-ийг шагнаж урамшуулах, үйлдвэрлэлийн зайлшгүй бусад шаардлагаар захиран зарцуулах;
- 3.1.7. Холбогдох хууль тогтоомж, дүрмийн дагуу ажилчин, ажилтан, албан тушаалтныг ажилд томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх, Хөдөлмөрийн тухай хуулийн Хөдөлмөрийн гэрээний нийтлэг зохицуулалт, хөдөлмөрийн гэрээний төрөл зэргийг үндэслэл болгон хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээ байгуулах, үр дүнг тооцох, дуусгавар болгох, цалин хөлсийг тогтоох;
- 3.1.8. Хууль тогтоомж, дүрэм, олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргах, Үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, аргачлал батлан мөрдүүлэх;
- 3.1.9. Эрх бүхий байгууллагаас тогтоосноос бусад өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг зохих журмын дагуу тогтоох;
- 3.1.10. Аливаа асуудлаар хууль хяналтын болон эрх бүхий бусад байгууллагад Үйлдвэрийн газрыг төлөөлөн санал хүсэлт, гомдол, нэхэмжлэл гаргах, шаардлага тавих;
- 3.1.11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталснаас бусад үйлдвэрлэл, эдийн засгийн болон технологийн бусад үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.1.12. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх.

3.2. Үйлдвэрийн газрын захирал дараах үүргийг хүлээнэ:

- 3.2.1. Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах;
- 3.2.2. Үйлдвэрийн газрын менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд сахих, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн өгөөжийг сайжруулах, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх, өртөг зардлыг хямдруулах, өр авлагыг бууруулах, ажилчин, ажилтан, албан тушаалтны нийгмийн асуудлыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу үе шаттай, оновчтой шийдвэрлэх;
- 3.2.3. Үйлдвэрийн өмч, хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглаулахтай холбогдсон гэрээг зохих журмын дагуу байгуулах, үр дүнг дүгнүүлэх;
- 3.2.4. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тухайн жилийн цэвэр ашгаас төлөх төрийн өмчийн ногдол ашгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон хэмжээгээр дараа жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор төвлөрүүлэх;
- 3.2.5. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоох, хамгаалах тогтолцоог бий болгох;

3.2.6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан маягт, аргачлалын дагуу зохих мэдээ, тайланг цаг тухайд нь гаргаж өгөх;

3.2.7. Гэрээний хэрэгжилтийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй бөгөөд биелэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын өмнө биечлэн хариуцах;

3.2.8. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан, мэдээ, мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тогтоосон хугацаанд үйлдвэрийн газрын болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим худсанд тухай бүр байршуулах;

3.2.9. Үйлдвэрийн газрын дараа жилийн зорилтын санал, түүнийг хэрэгжүүлэх саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу гаргаж, тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3.2.10. Төрийн өөрийн өмчийг бусдад түрээслүүлэхэд холбогдох хууль тогтоомж, захиргааны актыг мөрдөн ажиллах бөгөөд түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дансанд төвлөрүүлэх;

3.2.11. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутам хяналт тавьж, эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу явуулах;

3.2.12. Үйл ажиллагаандaa Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Авлигын эсрэг, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллах;

3.2.13. Дээд байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, тогтоосон хугацаанд хариу өгч, тайлагнаж байх;

3.2.14. Албан ажлаар гадаад улсад зорчих, эзлжийн амралтаа эдлэхэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад мэдэгдэж, зөвшөөрөл авч байх бөгөөд томилолтын тайланг Төрийн өмчийн бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэст ажлын З өдрийн дотор хүргүүлэх;

3.2.15. Гадаад улсад албан томилолтоор ажиллах хугацаандaa дипломат ёс жаягийг чанд баримталж, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх.

3.2.16. Гадаадад зорчихдоо мөрийтэй тоглоом /казино/ тоглож, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх.

3.2.17. Үйлдвэрийн газарт осол аваар гарч онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материал худалдан авах;

3.2.18. Захирал дараах асуудлыг зөвхөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй. Үүнд:

- ✓ үйл ажиллагааны үндсэн чиглэлээс өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;
- ✓ үйлдвэрийн газрын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах;
- ✓ үйлдвэрийн газрын барилга байгууламжийг зохих журмын дагуу түрээслүүлэх, түүнд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл өгөх;
- ✓ салбар, төлөөлөгчийн газар байгуулах;
- ✓ үйлдвэрийн газрын дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах;
- ✓ их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах;
- ✓ 50,000,000.00 (тавин сая) төгрөг болон түүнээс дээш хэмжээний зээл авах;
- ✓ өөрт олгогдсон эрх хэмжээнээс хэтэрсэн аливаа асуудал.

3.2.19. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## **Дөрөв. Цалин хөлс, урамшуулал, ажлын нөхцөл**

4.1. Захирлын албан тушаалын сарын үндсэн цалин нь  
..... (.....) төгрөг болно.

4.2. Захиралд үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон гэрээний биелэлтийг харгалzan холбогдох журмын дагуу урамшуулал олгох эсэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шийдвэрлэнэ.

4.3. Захирлын ээлжийн амралт болон хөдөлмөрийн харилцаатай холбогdon үүсэх, энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дотоод журмаар зохицуулна.

4.4. Гүйцэтгэх захирлыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагдах ажлын байр, суудлын автомашин, техник хэрэгслээр хангана. Суудлын автомашин, үүрэн телефон хэрэглээнд батлагдсан лимитийг баримтална.

4.5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шаардлагатай гэж үзсэн нөхцөлд захиралд нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь зориулж б хүртэл сарын үндсэн цалингаас хэтрүүлэхгүй хэмжээний мөнгөн тусламжийг тухайн үйлдвэрийн газрын санхүүгээс олгож болно.

4.6. Ажил олгогч өмчлөх эрхээ бусад этгээдэд бүрмөсөн шилжүүлсэн энэ гэрээний 5.2.1-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан захиралд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:

4.6.1. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол нэг ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

4.6.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хоёр жилээс тав хүртэл жил ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

4.6.3. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

4.6.4. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх.

4.7. Захирал өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор энэ гэрээний харилцаа дуусгавар болох нөхцөлд 3-6 сарын хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулан тухайн үйлдвэрийн газрын санхүүгээс олгож болно.

## **Тав.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг дуусгавар болгох**

5.1. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэн зохих журмын дагуу баталгаажуулах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

5.2.1. талууд харилцан тохирсон;

5.2.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;

5.2.3. хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;

- 5.2.4. ажлаас буруу халагдсан ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон;
- 5.2.5. захирал цэргийн жинхэнэ албанд татагдсан;
- 5.2.6. захирал гэмт хэрэг үйлдсэний улмаас ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
- 5.2.7. Гэрээг захирлын буюу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын санаачилгаар цуцалсан.

5.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Хөдөлмөрийн тухай хуулийн 65.4, 80 дугаар зүйлд зааснаас гадна дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй:

- 5.3.1. Зорилтот түвшинг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй.
- 5.3.2. Жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр тооцсон ногдол ашгийг төвлөрүүлээгүй.
- 5.3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зөрчсөн.
- 5.3.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас томилолтыг цуцалсан;
- 5.3.5. үйлдвэрийн газар татан буугдсан, дампуурсан;
- 5.3.6. үйлдвэрийн газар хувьчлагдаж, өмчлөгч өөрчлөгдсөн, өмчлөх эрхээ шилжүүлсэн;
- 5.3.7. захирлын буруу шийдвэр, үйл ажиллагаагаар үйлдвэрийн газарт хохирол учирсан, үйлдвэрийн газар алдагдалд орсон;
- 5.3.8. захирал хууль тогтоомж зөрчсөн, үйлдвэрийн газрыг удирдан зохион байгуулах үүргээ биелүүлээгүй;
- 5.3.9. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
- 5.3.10. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүргээ биелүүлээгүйгээс компанид ноцтой осол аваар гарсны улмаас хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан, компанид их хэмжээний хохирол учирсан;
- 5.3.11. өөр ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ буюу онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан;
- 5.3.12. Гэрээгээр захиралд шилжүүлсэн эд хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн, өмчлөгчөөс олгосон эрх мэдлийг хэтрүүлсэн нь тогтоогдсон;
- 5.3.13. захирлын буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ажил олгогчийн итгэлийг алдсан, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг давтан, эсхүл ноцтой зөрчсөн.
- 5.3.14. захирал мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болсон нь тогтоогдсон.
- 5.3.15.хуульд заасан бусад үндэслэл.

5.4. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсантай холбогдон үүсч болох тэтгэмж, нөхөн олговрын асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

### **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.

6.2. Захирал нь энэхүү гэрээ, холбогдох журмыг зөрчсөн нөхцөлд ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж болно.

6.3. Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр Хөдөлмөрийн тухай хуульд заасан тохиолдолд захирал нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

6.4. Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, бусад хууль тогтоомж, компанийн дүрэм, энэ гэрээнд заасан хөрөнгө эзэмших, ашиглах, захирал зарцуулах эрхээ хэтрүүлэх, урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж арилгана.

#### **Долоо. Бусад**

7.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, гэрээний хугацаа дууссанаар дуусгавар болно.

7.2. Энэхүү гэрээ нь “.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн хамт нийт ..... (.....) хуудас бөгөөд Монгол хэл дээр 3 (гурав) хувь үйлдэж, ажил олгогч 2, захирал 1 хувийг тус тус хадгална. Гэрээний эх хувь тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

7.3. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

##### **АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн удирдлага,  
зохицуулалтын хэлтсийн  
дарга .....

Хаяг: .....  
Утас: .....  
Факс: .....

##### **ЗАХИРАЛ:**

.....  
Хаяг: .....  
Утас: .....  
Регистрийн дугаар: .....

БАТЛАВ. ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

---

“.....” ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ  
ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

202.. оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар:.....

Улаанбаатар  
хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, түүнийг төлөөлж Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга .....  
“.....” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал ..... нарын хооронд 202.... оны ..... дугаар сарын ...-ны өдөр байгуулсан ..... дугаар бүхий “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлөөр 20... оны ..... дугаар сарын .....-ны өдөр хүртэл, 1 жилээр сунгав.

“.....” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 20.... оны .... дугаар улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан ..... (.....) төгрөгийн үндсэн, ..... (.....) төгрөгийн эргэлтийн, нийт ..... (.....) төгрөгийн хөрөнгийг онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг сунгасан өдөр хүлээлгэн өгөв.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИРАЛ:

Төрийн өмчийн удирдлага,  
зохицуулалтын хэлтсийн  
дарга .....

.....

Хаяг: .....  
Утас: .....  
Факс: .....

Хаяг: .....

Утас: .....

Регистрийн дугаар: .....

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн  
18 дугаар 3 дугаар хавсралт

**“.....” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ  
ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

Энэхүү гэрээг НЭГ ТАЛААС: “.....” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ..... НӨГӨӨ ТАЛААС: “.....” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал ....., ....., регистрийн дугаартай ..... аймгийн ..... сумын ... дугаар баг, .... тоотод оршин суугч/ нар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ..... тоот албан бичгээр өгсөн чиглэл, “.....” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны .... дугаар сарын ....-ны өдрийн .... дугаар тогтоолыг үндэслэн харилцан тохиролцсоны дагуу энэхүү онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг (цаашид “Гэрээ” гэх) дараах нөхцөлөөр байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Компанийн эд, хөрөнгийг үр ашигтай эзэмшин, ашиглах, захиран зарцуулснаар компанийн үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, эдийн засгийн үр ашиг, хөрөнгийн өгөөжийг дээшлүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулах, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Гүйцэтгэх захирал үйл ажиллагаандaa Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Шилэн дансны хууль, Мэдээллийн ил тод байдлын хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль, тогтоомж, компанийн дүрэм, энэхүү гэрээ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг удирдлага болгон ажиллана.

1.3. Гүйцэтгэх захирал гуравдагч этгээдээр ажлаа гүйцэтгүүлэхгүй, өөр аж ахуйн нэгжид ажиллахгүй байж зөвхөн энэ гэрээгээр тохиролцсон үүрэг, хариуцлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө биечлэн хариуцна.

**Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг**

2.1. “.....” Төрийн өмчит хувьцаат компанийн нийт ..... төгрөгийн хөрөнгийг гүйцэтгэх захиралд томилогдсон өдрөөр тасалбар болгон зохих журмын дагуу хүлээлгэж өгнө. Жил бүр жилийн эцсийн тайлан тэнцлийн дүнгээр хөрөнгийг баталгаажуулж, гэрээний сунгалтад тусгаж байх.

2.2. Гүйцэтгэх захиралд цалин хөлс, бусад шагнал урамшууллыг энэхүү гэрээний 6 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу олгоно.

2.3. Гүйцэтгэх захирал гэрээнд тусгагдсан үүргээ зохих ёсоор биелүүлэхтэй холбогдуулж түүний тавьсан саналуудыг цаг тухайд нь шийдвэрлэн өгч байна.

2.4. Төлөөлөн удирдах зөвлөл (гишүүн) нь Гүйцэтгэх захирал хууль болон энэхүү гэрээг зөрчсөн гэм буруутай үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэнэ.

2.5. Компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гэрээний хавсралтаар батална.

2.6. Гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үүргээ биелүүлэх явцад халдлагад өртөх, нэр төрөө гутаалгах, шахалт дарамтад орох тохиолдолд түүний хүсэлтээр зохих арга хэмжээг эрх хэмжээнийхээ хүрээнд авч хэрэгжүүлнэ.

### **Гурав.Гүйцэтгэх захирлын үүрэг**

3.1. Компанийн тухай хууль, холбогдох хууль, дүрмийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, аж ахуйн менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг биелүүлэх, үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, осол аюулгүй ажиллагааг хангаж, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэж, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллана.

3.2. Гүйцэтгэх захирал компанийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргаж 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

3.3. Гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу компанийн "Зорилтын санал"-ын талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай тохиролцох бөгөөд түүнд үндэслэн гаргасан тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг гэрээний хавсралтад тусгасан үзүүлэлтүүдээр биелүүлэн ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүргийг хүлээнэ.

3.4. Гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт хийлгэх бөгөөд тайланг аудитын дүгнэлтийн хамт мөн хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

3.5. Гэрээний биелэлт, ажлын тайлангаа Төлөөлөн удирдах зөвлөлд хэлэлцүүлэн гарсан шийдвэр, дүгнэлтийг компанийн жилийн эцсийн тайлан тэнцлийн хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

3.6. Гүйцэтгэх захирал дараах асуудлуудыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

3.6.1. Эрхлэх бизнесийн үндсэн төрөл, чиглэлээс өөр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах;

3.6.2. Ажиллагсдын нийгэм хангамжийн шинж чанартай хөрөнгө оруулалт хийх;

3.6.3. Компанийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгийг данснаас хасах, захиалах, шинээр авах;

- 3.6.4. Бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах;
- 3.6.5. Бусад этгээдэд компанийн барилга, байгууламжийг түрээслүүлэх;
- 3.6.6. Түрээслүүлсэн барилга, байгууламжид нийт хөрөнгийн /үнийн дүнгийн 10/ хувиас дээш хэмжээтэй хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгоходоо Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан журмыг баримтлана.
- 3.6.7. Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв батлах;
- 3.6.8. Компанийн дүрмэнд заасан эрх бүхий албан тушаалтнуудыг томилох, чөлөөлөх, тэдгээртэй байгуулах хөдөлмөрийн гэрээг батлах, цуцлах;
- 3.6.9. Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулах.
- 3.6.10. Их хэмжээний хэлцэл хийх, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох. /Аливаа гэрээ хэлцлийн хэрэгжих хугацаа нь энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанаас илүү байж болохгүй/

3.7. Гүйцэтгэх захирал нь бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй, хэрэгцээнээс илүү хэмжээний үндсэн ба туслах материал, үндсэн үйлдвэрлэлтэй холбогдолгүй бараа, техник хэрэгсэл худалдан авах тухай гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ хэлцэл хийхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авна.

3.8. Гүйцэтгэх захирал банкнаас зээл авах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж зөвшөөрөл авч байна.

3.9. Гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр компанийн эд хөрөнгөөс зээл олгох, хандивлах, бэлэг өгөх, бусдад хөрөнгийн баталгаа гаргахыг хориглоно.

3.10. Гүйцэтгэх захирал нь тогтсон журмын дагуу хувь нийлүүлэгчдэд олгох ногдол ашгийн тооцооллыг УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу тооцож, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

3.11. Гүйцэтгэх захирал компанийн үйл ажиллагааны үр дүнд олсон цэвэр ашгаас хувь нийлүүлэгчдэд олгох ногдол ашгийн хэмжээг тогтоох шийдвэр гарснаас хойш 1 сарын дотор териин өмчид ногдох ногдол ашгийг төвлөрүүлж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тухай бүр мэдээлнэ.

3.12. Компанийн үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоож, түүнийг хамгаалах тогтолцоог бий болгоно.

3.13. Гүйцэтгэх захирал компанийн нийт ажиллагсадтай хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллана.

3.14. Төлөөлөн удирдах зөвлөлд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн улирал, хагас, бүтэн жилийн тайлан тэнцлийн үр дүнгийн талаар үнэн зөв мэдээлэл өгч тайлан тавина.

3.15. Гүйцэтгэх захирал нь компанийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг удирдан зохион байгуулж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө хариуцна.

3.16. Компанийн эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журмын дагуу хийж хагас, бүтэн жилийн тайлан тэнцэлд тусгана.

3.17. Компанийн санхүүгийн тайлан тэнцлийг хуульд заасан журмын дагуу гаргах ажлыг зохион байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэн тайлангийн нэг хувийг дараа сарын 25-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж баталгаажуулна.

3.18. Гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 97.1-д хамарагдах нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран ажиллаж байгаа бол энэ тухай Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэнэ.

3.19. Гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг бичгээр мэдэгдэнэ.

3.20. Гүйцэтгэх захирал нь Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Шилэн дансны хууль, Мэдээллийн ил тод байдлын хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль, тогтоомж, компанийн дүрэм, энэхүү хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр болон холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллана.

3.21. Компанийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан зэрэг Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд компанийн болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын вэб сайтад тогтмол байршуулна.

3.22. Гүйцэтгэх захирал нь албан ажлаар гадаад улсад зорчих болон ээлжийн амралтаа эдлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад заавал бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авсан байна.

3.23. Гадаад улсад албан томилтоор ажиллах хугацаандаа дипломат ёс жаягийг чанд баримталж, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх.

3.24. Гадаадад зорчихдоо мөрийтэй тоглоом /казино/ тоглож, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх.

### **Дөрөв.Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх**

4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай танилцах, шалгах, зөвлөх эрхтэй бөгөөд түүнд өгөх даалгаврыг тогтоол, тэмдэглэл хэлбэрээр өгнө.

4.2. Гүйцэтгэх захирал өөрийн үйл ажиллагаагаар компанийд хохирол учруулсан гэж Төлөөлөн удирдах зөвлөл үзвэл хохирол зардлыг нөхөн төлүүлэх асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

4.3. Төлөөлөн удирдах зөвлөл шаардлагатай гэж үзвэл өөрийн төлөөлөгчийг тодорхой хугацаагаар томилон Компанийн болон Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх эрхтэй.

4.4. Төлөөлөн удирдах зөвлөл улирал бүр, шаардлагатай гэж үзвэл сар бүр компанийн бизнесийн үйл ажиллагааны талаар гүйцэтгэх захирлын мэдээллийг сонсоно.

4.5. Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, гэрээний үүргийн биелэлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч Гүйцэтгэх захиралд олгох урамшууллын хэмжээ, эсвэл хүлээлгэх хариуцлагын талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлнэ.

4.6. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тайлан тэнцэл, мэдээ, судалгаанд үндэслэн тэдгээрийн менежментийн байдал, үйлдвэрлэл, технологи, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтэд улирал, хагас, бүтэн жилээр судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

4.7. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөл компанийн удирдлага, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох яам, газартай хамтран мэргэжлийн хүмүүсийг оролцуулан хяналт шалгалт хийж болно.

4.8. Гүйцэтгэх захирал 30-иас дээш хоногийн хугацаагаар эзэнгүй байх /энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцлийг хэлнэ/ тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх захиралтай зөвшилцэн үүрэг гүйцэтгэгчийг томилж, эрх, үүргийн хэмжээг тогтоож өгнө.

#### **Тав.Гүйцэтгэх захирлын эрх**

5.1. Компанийн эд хөрөнгийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор захирсан зарцуулна.

5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэхээс бусад асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд гэрээ, хэлцэл байгуулна. Үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагаа, техник, технологит осол аваарь гарч онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагатай сэлбэг, материалыг худалдан авах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцэн шийдвэрлэнэ.

5.3. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулах саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд гаргаж болно.

5.4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх, хэмжээний хүрээнд компанийг төлөөлж, шүүхэд нэхэмжлэл гаргана.

5.5. Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, тогтоомжид нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар, журам гаргана.

#### **Зургаа. Цалин хөлс, урамшуулалт, ажлын нөхцөл**

6.1. Гүйцэтгэх захиралд сард .....(.....) төгрөгийн цалин хөлс олгоно.

6.2. Гүйцэтгэх захиралд гэрээнд хавсаргасан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр ашгийн байдал, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, дараа оны ажлын

бэлтгэл зэргийг харгалзан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан журмыг баримтлан урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.

6.3. Гүйцэтгэх захирлын ажил, амралтын цаг болон ээлжийн амралт нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу зохицууллагдах бөгөөд ээлжийн амралт эдлэх үедээ Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад заавал бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авна.

6.4. Гүйцэтгэх захирлын албан үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын байр, суудлын автомашин, техник хэрэгслээр хангана. Үүрэн телефон хэрэглэх зардал, суудлын автомашин гүйлтийг тогтоохдоо Засгийн газар, холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон лимитыг баримтална. Гүйцэтгэх захирал ээлжийн амралтын хугацаанд албаны суудлын автомашин хэрэглэх жилийн лимитэд багтаан үйлчлүүлэх эрхтэй.

6.5. Гүйцэтгэх захирал албан үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар алдвал Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр б хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нөхөн олговор олгож болно.

6.6. Ажил олгогч өмчлөх эрхээ бусад этгээдэд бүрмөсөн шилжүүлсэн энэ гэрээний 8.2, 8.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан захиралд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:

6.6.1. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол нэг ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

6.6.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хоёр жилээс тав хүртэл жил ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

6.6.3. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх;

6.6.4. тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх.

6.7. Захирал өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор энэ гэрээний харилцаа дуусгавар болох нөхцөлд 3-6 сарын хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулан тухайн компанийн санхүүгээс олгож болно.

#### **Долоо. Хариуцлага**

7.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль, тогтоомж, компанийн дүрэм, гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

7.2. Гүйцэтгэх захирлын гэм буруутай үйл ажиллагаагаар хууль, компанийн дүрэм, энэ гэрээгээр Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эд хөрөнгийн эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглах зэргээр компанийн хувь нийлүүлэгчдэд хохирол учруулсан бол түүнийг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцаж барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах үндэслэл болно.

**Найм. Гэрээнд өөрчлөлт оруулах,  
гэрээг цуцлах**

8.1. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Мөн тухайн хөдөлмөрийн гэрээний хүчинтэй хугацаанд гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж болох ба гэрээний өөрчлөлтийг бичгээр хийж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээ нь дор дурьдсан үндэслэлээр дуусгавар болно:

- а. Гэрээний хугацаа дууссан;
- б. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гэрээг цуцлах шийдвэр гаргасан;
- в. Гүйцэтгэх захирлын өөрийн хүсэлтээр;
- г. Компани дампуурсан;
- д. Компанийн териийн мэдлийн хувьцаа худалдагдсан

8.3. Гүйцэтгэх захирлын санаачлагаар дараах тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө цуцлана:

- а. Өвчний улмаас компанийг удирдах чадваргүй болсон;
- б. Бусад хүндэтгэх шалтгаан бий болсон

8.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь Хөдөлмөрийн тухай хуулийн 65.4, 80 дугаар зүйлд зааснаа гадна дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй:

8.4.1. Хувьцаа эзэмшигчээс гэрээг цуцлах талаар Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгсөн бол;

8.4.2. Гүйцэтгэх захирал гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол;

8.4.3. Үйлдвэрлэлийн хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүргээ биелүүлээгүйгээс ноцтой осол, аваарь гарсан нөхцөлд гэрээг цуцлах үндэслэл болгоно.

8.4.4. Гүйцэтгэх захирлын өөрийнх нь буруу шийдвэр, үйл ажиллагаагаар компанийд хохирол учирсан, компани алдагдалд орсон;

8.4.5. Гүйцэтгэх захирал хууль, тогтоомж болон компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргээ зөрчсөн, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;

8.4.6. Гүйцэтгэх захирал өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй шалтгаан нөхцлүүд бий болсон;

8.4.7. Гүйцэтгэх захирал 6 сараас дээш хугацаагаар хөдөлмөрлөх чадваргүй болсон;

8.4.8. Компани татан буугдсан;

8.4.9. хөдөлмөрийн гэрээгээр захиралд шилжүүлсэн эд хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн, өмчлөгчөөс олгосон эрх мэдлийг хэтрүүлсэн нь тогтоогдсон;

8.4.10. захирлын буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ажил олгогчийн итгэлийг алдсан, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг давтан, эсхүл ноцтой зөрчсөн.

8.4.11. захирлын буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ажил олгогчийн итгэлийг алдсан, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг давтан, эсхүл ноцтой зөрчсөн.

8.4.12. захирал мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болсон нь тогтоогдсон.

8.4.13. Хуульд заасан бусад үндэслэлүүд;

8.5. Энэ гэрээ дуусгавар болсон, хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдлыг тогтоож, компанийн эд хөрөнгийн тооллого явуулан буртгэж, дараагийн гүйцэтгэх захиралд ажил хүлээлцүүлнэ.

8.6. Гэрээг хугацаанаас өмнө цуцалсантай холбогдон гарч болох нөхөн олговор олгох асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

#### Ес. Гэрээний хугацаа

9.1. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэх захиралтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай” ..... ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 20.. оны ... дугаар сарын ....-ны өдрийн .... дугаар тогтоол гарсан өдрөөс эхлэн 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

“.....” ТӨХК-ийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 20.. оны ..... дүгээр сарын .....-ний ..... дүгээр тогтоолоор баталсан “.....” ТӨХК-ийн 20.. оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг гэрээнд хавсаргана.

9.2. Гэрээний биелэлтийг талууд дүгнэж, гэрээг сунгахаар шийдвэрлэсэн нөхцөлд сунгах хугацааг тогтоож, энэ тухай тэмдэглэл үйлдэж гэрээнд хавсаргаж мөрдөнө.

#### Арав.Бусад

10.1. Гүйцэтгэх захирал төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

10.2. Энэ гэрээний талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан эх хувь адил хүчин төгөлдөр байна. Энэ гэрээний талууд гарын үсэг зурж оруулсан нэмэлтүүд, гэрээний үндсэн нөхцөлтэй адил хүчин төгөлдөр байна.

10.3. Гэрээний талуудын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид заасан журмаар шийдвэрлэнэ.

10.4. Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

10.5. Энэхүү гэрээ 3 хувь үйлдэж, Гүйцэтгэх захирал, Төлөөлөн удирдах зөвлөл болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.....(.....)

“.....” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....(.....)